

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/28

Өлгий

Г 7

Эрүүл мэндийн яамнаас хуваарилагдсан
тоног төхөөрөмжийг /автоклав/ хүлээн авах
комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн яамнаас хуваарилагдсан тоног төхөөрөмжийг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:

М.Рустем- Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга

Гишүүд:

Т.Нурсауле - Эм эмнэлгийн хэрэгслийн хангамж, төлөвлөлт худалдан авалт хариуцсан мэргэжилтэн

А.Нургүл -Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн

С.Еншигүл- Нярав

Нарийн бичгийн дарга:

С.Бекет - Эмнэлгийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ хариуцсан ажилтан.

2. Нийлүүлсэн тоног төхөөрөмжийг холбогдох баримтуудтай газар дээр нь танилцаж, шалгаж авах, хүлээн авсан тухай акт үйлдэн үндсэн хөрөнгөд бүртгэн авч ажиллахыг нярав /С.Еншигүл/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга /Ш.Иманхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.САКЕН